

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

АУДИТЫН КОД: БУА-2022/20-4/ШТА-ГА

БУЛГАН АЙМАГ
2023

Булган дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ
Утас: 7034-2580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 7034-2716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор: П.Содном
Утас: 7034-2495 Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn
Аудитор: З.Ганбаатар
Утас: 7034-2716 Цахим хаяг: Ganbaatarz@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. bulgan@audit.gov.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	4
Хүснэгтийн товъёг	4
Дүрслэл.....	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	5
А. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх тогтолцоо бүрдээгүй байна.....	6
А.1 Шинээр эрх шилжиж ирсэн 1 төсөл арга хэмжээ нь улсын болон орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцсэн байна.	6
А.1.1 “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байна.....	6
А.1.2 Шинээр эрх шилжиж ирсэн 1 төсөл арга хэмжээ нь Засгийн газрын болон аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй нийцсэн байна.....	6
А.1.3 Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдсан, төсөл арга хэмжээ болсон байна.....	7
А.2 Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх бодлогын хэрэгжилтийг хангуулаагүй байна.....	7
А.2.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан төсөл арга хэмжээ нь орон нутгийн төсөвт байгууллагын өмчлөлд шилжих, бүртгэх боломжтой байна.....	7
А.2.2 ТЭЗ-ын хөрөнгө оруулалтын эрэмбэлсэн жагсаалтад багтаагүй, орон нутгийн саналгүй төсөл арга хэмжээ батлагдаж хэрэгжсэн байна.....	7-8
А.2.3 Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө төсөвлөлтийн шаардлагыг бүрэн хангаж ажиллаагүй байна.....	7-8
А.2.4 ТЭЗ-ын хөрөнгө оруулалтын эрэмбэлсэн жагсаалтад тусгаагүй, төсөл, арга хэмжээ төлөвлөсөн нь хөрөнгийн ашиглалттай холбоотой төлөвлөлтийн ажлууд хийгдээгүй байна.....	8
А.2.5 Шинээр хэрэгжиж буй төсөл арга хэмжээний зураг төсөв магадлалд хянуулаагүй ажил эхэлснээс хөрөнгө оруулалтын ажлын төсөвт өртөг нэмэгдэх, ажил удааших нөхцөл байдал үүсэж болзошгүй байна.....	9
Б. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, УЛСЫН ТӨСВӨӨС ОЛГОСОН САНХҮҮЖИЛТИЙН ЗАРЦУУЛАЛТ ҮР ДҮНТЭЙ БАЙНА.....	9
Б.1 Гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулсан байна.	9
Б.1.1 Төсөл, арга хэмжээг тайлант онд хэрэгжих боломжтой хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.....	9-10
Б.1.2 Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулж, батлуулсан байна.....	10-11
Б.1.3 Гүйцэтгэгчийг ил, тод нээлттэй байдлаар сонгон шалгаруулсан байна.....	11
Б.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 1 ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ ГЭРЭЭНД ЗААСАН ХУГАЦААНД ГҮЙЦЭТГЭЭГҮЙ БУСАД ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ БҮРЭН ХЭРЭГЖСЭН БАЙНА.....	11
Б.2.1 Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөснөөс 70 хувийн гүйцэтгэлтэй 1 ажил гэрээний хугацаандаа хэрэгжээгүй зогссон байна.	11-12
Б.2.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжиж ирсэн их засварын ажил байхгүй байна.	12-13

Б.2.3 Техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу 17 нэр төрлийн 89 ширхэг тоног төхөөрөмжийг бүрэн нийлүүлсэн байна.....	13
Б.2.4 Төсөл арга хэмжээний ТЭЗҮ ангилалд тусгагдсан төсөл, арга хэмжээ байхгүй байна.....	14
Б.2.5 Он дамжсан дуусаагүй орхигдсон төсөл, арга хэмжээ байхгүй байна.....	14
Б.3 ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ТАЙЛАН МЭДЭЭГ ҮНДЭСЛЭН САНХҮҮЖИЛТИЙГ ОЛГОЖЭЭ.	14
Б.3.1 Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн хугацаанд нь бүрэн олгосон байна.	14-15
Б.4 Төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих дотоод хяналтын тогтолцоо үр дүнгүй байна.....	15
Б.4.1 Барилга угсралтын ажил гүйцэтгэсэн тэмдэглэл хийх дэвтэрт захиалагч, зохиогчийн хяналтын тэмдэглэл хөтлөөгүй байна.....	15-16
Б.4.2 Хөрөнгө оруулалтын үйл явцад дотоодын хяналт тавих чиг үүрэг хэрэгжихгүй байна.....	16
Б.5 ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ХҮЛЭЭН АВАХ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА.....	16
Б.5.1 Он дамжсан болон шинээр эрх шилжиж ирсэн 4 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж холбогдох хууль, журмын дагуу ажлыг хүлээн авч дүгнэлт гаргасан байна.....	16-17
Б.5.2 Ашиглалтад хүлээн авсан төсөл арга хэмжээнээс гэрээнд заасан хугацаанаас хоцорсон 1 ажлын 0.7 сая төгрөгийн алданги тооцоогүй байна.	17-18
Б.5.3 Хөрөнгө оруулалтаар бий болсон 1115.3 сая төгрөгийн 3 барилга байгууламжийн өмчлөлийн асуудлыг шийдвэрлээгүй байна.....	18-19
В.1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ЖИЛИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ БҮРЭН НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.....	19
В.1.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар батлагдсан төсөл арга хэмжээний 54.5 хувийг жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгаагүй байна.....	19-20
В.1.2 ОНХО-аар зураг төсөв, ТЭЗҮ хийгдээгүй 16 төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.....	20-21
В.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ 84.8 ХУВИЙН ГҮЙЦЭТГЭЛТЭЙ БАЙНА.....	21
В.2.1 Худалдан авах ажиллагааны журмыг сонгох босго үнийг баримтлаагүй 1 төсөл арга хэмжээ байна.....	21
В.2.2 Бүрэн хэрэгжсэн 2,370.8 сая төгрөгийн 28 төсөл, арга хэмжээг захиалагч байгууллагаас хүлээн авах комисс томилон ажлыг ашиглалтад оруулах комиссын тухай бүрд нь томилон ажилладаг байна.....	22-23
В.2.3 ОНХО-ын гэрээний хэрэгжилтээс 72.5, хэрэгжээгүй 3 төсөл, арга хэмжээний 186.1 сая төгрөгийн хэмнэлт үүсэж орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлсэн байна.....	23
В.2.4 Захиалагчийн хяналтаар илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрд нь зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажилладаг байна.....	24
В.2.5 Тайлант онд хэрэгжсэн барилга, байгууламж, тоног төхөөрөмжөөс 1 төсөл, арга хэмжээг үнийн зөрүүтэй, 3 төсөл, арга хэмжээг бүртгэл тайланд тусгаагүй байна.....	24-25
Дүгнэлт.....	25-26
Зөвлөмж.....	26

Товчилсон үгийн тайлбар

БОАЖС	Байгаль орчин аялал, жуулчлалын сайд
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОБГ	Онцгой байдлын газар
СХАА	Санхүү хяналт аудитын алба
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
СТХС	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
БХБХ	Барилга, хот байгуулалтын хэлтэс
ТАХ	Төсөл арга хэмжээ
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээ	7
Хүснэгт 2	Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан төсөл арга хэмжээ	10-11
Хүснэгт 3	Он дамжин хэрэгжиж буй төсөл арга хэмжээний гүйцэтгэл	12
Хүснэгт 4	Тайлант онд эрх шилжсэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл	13
Хүснэгт 5	Тайлант онд эрх шилжсэн техник, тоног төхөөрөмжийн гүйцэтгэл	14
Хүснэгт 6	2022 оны олгосон санхүүжилт, зарцуулалтыг хүснэгтээр харуулбал	15-16
Хүснэгт 7	2022 онд гэрээний хэрэгжилт биелсэн, хүлээн авсан төсөл арга хэмжээг хүснэгтээр харуулбал	18
Хүснэгт 8	Бүртгэлд авсан байгууллагын жагсаалтыг хүснэгтээр харуулбал	19
Хүснэгт 9	Бүртгэлд тусгаагүй төсөл арга хэмжээний жагсаалт	20
Хүснэгт 10	Зураг төсөө, ТЭЗҮ хийгдээгүй төсөл, арга хэмжээ	22
Хүснэгт 11	Он дамжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ	23-24
Хүснэгт 12	Хөрөнгийн бүртгэлд тусгах төсөл, арга хэмжээний тоо, дүн	26

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл №1	Төлөвлөсөн төсөл, арга хэмжээ ангилаар	21

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 09 дугаар тогтоолын дагуу хийнэ.
Аудитын зорилт	Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулж дүнг Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: - Хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээг хууль, хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлэн төлөвлөсөн эсэх; - Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа хуульд нийцсэн эсэх; - Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт үр дүнтэй хэрэгжсэн эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Аудитад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд эрх шилжиж ирсэн 7, ОНХО-аар 33 төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны төв болон бусад байгууллага болон төсөл арга хэмжээг гүйцэтгэгч нарын холбогдох үйл ажиллагааг хамруулаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-400, АДБОУС-3000-3100, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020, Гүйцэтгэлийн аудитын зарчим", MNS 6817-6:2020 нийцлийн аудитын зарчим", MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 нийцлийн аудитын стандарт, "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам", Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал, арга зүйг ашиглан ҮАГ-аас ирүүлсэн асуудлын шинжилгээ, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, судалгаа, дүн шинжилгээ хийж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ хянан удирдаж, аудитын аудитын менежер Ж.Энхцоодол үе шатны чанарын хяналтыг хийж, ахлах аудитор П.Содном, аудитор З.Ганбаатар нар хийж гүйцэтгэлээ. Аудитын удирдамжийн дагуу гүйцэтгэлийн аудитыг 2022 оны 04 дугаар сарын 03-ны өдрөөс 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл ажлын 17 хоногт хийж аудитыг үе шатны хяналтаар хянуулж аудитын тайланг хавсралт судалгааны хамт 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр ҮАГ-т, аймгийн ЗДТГ болон ГХБХБГ-т тус тус хүргүүлэн ажилласан болно.
Хүндрэл бэрхшээл	Санхүүгийн тайлангийн аудитын хугацаатай давхцах, аудитын үр дүнг нэгтгэх системд оруулах ажилтай байсан, СТХС хөрөнгө оруулалтын мэргэжилтэн солигдсонтой холбоотой баримт материал судалгааны ажлууд хугацаа алдаж ажлын ачаалал их байсан,

БҮЛЭГ А. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨХ ТОГТОЛЦОО БҮРДЭЭГҮЙ БАЙНА.

А.1 Шинээр эрх шилжиж ирсэн 1 төсөл арга хэмжээ нь улсын болон орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцсэн байна.

А.1.1 “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байна.

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" урт хугацааны бодлогод нийцүүлсэн Булган аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Булган аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөг аймгийн ИТХ-аас баталсан байна.

Шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн /Халуун усны барилга, Булган, Могод сум/ арга хэмжээ нь “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцсэн байна.

А.1.2 Шинээр эрх шилжиж ирсэн 1 төсөл арга хэмжээ нь Засгийн газрын болон аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй нийцсэн байна.

Улсын төсвийн хөрөнгөөр Булган аймагт 91,037.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 30 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж орон нутагт 3,929.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл арга хэмжээний эрх шилжсэнээс он дамжин хэрэгжиж буй 4 төсөл арга хэмжээг 2022 онд санхүүжүүлэхээр 873.0, шинээр хэрэгжих 165.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 арга хэмжээнд 165.0 сая төгрөгийг олгохоор баталжээ.

Хүснэгт № 1 Эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээ

/сая.төг/

№	Төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	2022 санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
1	Сургуулийн өргөтгөлийн барилга, 240 суудал /Булган, Хутаг-Өндөр сум/	2019	2022	1500	197.3
2	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 75 ор /Булган, Булган сум, 3 дугаар цэцэрлэг/	2020	2021	1,169.6	245.7
3	Хүүхдийн "Жаргалант" зуслангийн захиргаа, аж ахуй, гал тогооны барилга /Булган/	2020	2022	920	255
4	Соёлын төвийн тоног төхөөрөмж /Булган/	2021	2022	175.0	175
5	Халуун усны барилга /Булган, Могод сум/	2022	2022	165.0	165
	Дүн			3929.6	1,213.0

Булган аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Булган аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнүүдэд тусгагджээ.

А.1.3 Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдсан, төсөл арга хэмжээ болсон байна.

Булган аймаг 2021 оныг "Аяллын хог хаягдалгүй аймаг", 2022 оныг "Ногоон аялал жуулчлалыг дэмжсэн, байгаль эх дэлхийдээ ээлтэй аялал жуулчлалын жил" болгон зарласан байна.

БОАЖС-ын багцаас улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр баталсан төсөл арга хэмжээнээс Булган аймагт "Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн газар, авто зогсоол бүхий отоглох цэг"-ийг Баян-Агт сумын Хануй гол, Рашаант сумын Элсэн тасархайд байгуулахаар тус бүр 100.0 нийт 200.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээ орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн нь орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдсан төсөл арга хэмжээ болсон байна.

А.2 Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх бодлогын хэрэгжилт хангалтгүй байна.

А.2.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан төсөл арга хэмжээ нь орон нутгийн төсөвт байгууллагын өмчлөлд шилжих, бүртгэх боломжтой байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн өмчлөлийн асуудлыг Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 5.3.5-д "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн бүртгэл, өмчлөлийн асуудлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу шийдвэрлэнэ." гэж заасан.

Булган аймагт эрх шилжиж ирсэн 5, БОАЖС-ын багцаас 2 нийт 7 төсөл, арга хэмжээнээс шинээр 165.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Могод сумын халуун усны барилгын 1, сайдын багцаас эрх шилжиж ирсэн 2 суманд хийгдэх аялал, жуулчлалын отоглох цэг байгуулах 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлж байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 17 дугаар тогтоолд улс орон нутгийн төсвөөр бий болсон үндсэн хөрөнгийг тухай бүр нь Өмчийн албанд бичгээр мэдэгдэж, хянуулсны дараа байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгаж байх зохицуулалттай дээрх төсөл арга хэмжээнүүд нь сумын ЗДТГ-ын өмчлөлд шилжих боломжтой хөрөнгө оруулалтууд байна.

А.2.2 ТЕЗ-ын хөрөнгө оруулалтын эрэмбэлсэн жагсаалтад багтаагүй, орон нутгийн саналгүй төсөл арга хэмжээ батлагдаж хэрэгжсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг аймгийн Засаг дарга 2021 оны 09 дүгээр сарын 01-нд баталжээ.

Уг жагсаалтад орон нутагт эрх шилжиж ирсэн Могод сумын халуун усны барилга нь ороогүй бөгөөд орон нутгаас холбогдох яамдад хөрөнгө оруулалтад тусгуулах санал хүргүүлээгүй байна.

Төсөл арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдолтой үр дүнгийн талаарх тооцоолол, судалгаа хийж баримтжуулсан материал байхгүй, төсвийн хөрөнгө оруулалт удирдлагын pimis.publicinvestment.gov.mn цахим системд цалин, НДШ зардлыг тооцоо оруулснаас өөр мэдээлэлгүй байна.

Төсвийн хөрөнгө оруулалтад тавигдах шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээ жагсаалтад батлагдсаар байгааг анхаарч ЗГ-ын 2021 оны 160 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллан уг зөрчлийг давтан гаргахгүй төлөвлөлтийн шаардлага хангасан төсөл арга хэмжээнд санал хүргүүлж байх шаардлагатай байна.

А.2.3 Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө хуульд заасан шаардлагыг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4¹, Газрын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4², Сангийн сайдын 2021 оны 160 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт тайлагналтын журам”-ын 3.2.1³ дахь шаардлагад нийцүүлэн төлөвлөхөөр заасан.

Шинээр хэрэгжиж буй Халуун усны барилга /Булган, Могод сум/ 165.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээний зураг төсвийг 2020 онд “Эчо дизайн” ХХК хийж гүйцэтгэн, газрын зөвшөөрлийг сумын Засаг даргын 2020 оны А/162 захирамжаар олгосон байна. Тус ажлын зураг төсвийг магадлалаар хянуулаагүй ажил эхэлснээс шалтгаалан ажил зогсож, санхүүжилт олгоогүй байна.

Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг баталж байгаа нь хөрөнгө оруулалтын ажил удаашрах, гэрээний хугацаанд хэрэгжих боломжгүй болох, төсөвт өртөг нэмэгдэх эрсдэлүүд үүссэн байна.

А.2.4 ТЕЗ-ын хөрөнгө оруулалтын эрэмбэлсэн жагсаалтад тусгаагүй, төсөл, арга хэмжээ төлөвлөсөн нь хөрөнгийн ашиглалттай холбоотой төлөвлөлтийн ажлууд хийгдээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.4-д “Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засгийн газар, Засаг даргын аливаа шийдвэр нь төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх дүгнэлтэд үндэслэсэн байх;” мөн хуулийн 27 дугаар зүйлийн 27 дүгээр зүйлд улсын хөрөнгө оруулалтын урьдчилсан үнэлгээ, 29 дүгээр зүйлд төсвийн хөрөнгө оруулалтад тавигдах шаардлагыг хангасан хөрөнгө оруулалтыг төсөвт тусгаж байх заалттай.

2022 онд шинээр эрх шилжиж ирсэн 1 төсөл арга хэмжээ нь орон нутгаас санал хүргүүлээгүй, 2022 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад төлөвлөөгүй ажил батлагдсанаас урьдчилсан үнэлгээ, урсгал зардлын тооцоо, орон тоо, төсөвт нөлөөлөх ачаалал зэрэг төлөвлөлтийн ажлууд хийгдээгүй байна.

¹ 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

² 31.4.Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авсан байна.

³ 3.2.1.Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл нь Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалд заасны дагуу шалгуур үзүүлэлтээр үнэлэгдсэн, эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой, тэргүүлэх зэрэглэлийн төслүүд байна.

А.2.5 Шинээр хэрэгжиж буй төсөл арга хэмжээний зураг төсөв магадлалд хянуулаагүй ажил эхэлснээс хөрөнгө оруулалтын ажлын төсөвт өртөг нэмэгдэх, ажил удаашрах нөхцөл байдал үүсэж болзошгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 зугаар зүйлийн 13.1-д Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад баримтлах 7 заалтыг тусгасан байна. Үүнээс 2022 онд хэрэгжүүлж ажиллах зүйл заалтыг авч үзлээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилтийг хөрөнгө оруулалтын pimis.publicinvestment.gov.mn программаар хянаж эхэлснээр төсөл арга хэмжээний санхүүжилтийг гэрээний дүнгээр олгож худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлт улсын төсөвт үлдэж байна.

Шинээр хэрэгжиж буй Могод сумын халуун усны барилгын ажил эхэлсэн 70 хувьтай, 2020 оны зураг төсөвтэй ажил эхэлсэн, магадлалд хянуулаагүй шалтгаантаар ажил зогссон, Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсөвт өртөг нэмэгдүүлэх үр дагавар бүхий нэмэлт шаардлагыг зохиогч, ашиглагч, захиалагчийн хяналт тавих этгээд гаргахгүй байхаар заасан ч тус хөрөнгө оруулалтын ажлын төсөвт өртөг нэмэгдэх, ажил удаашрах нөхцөл байдал үүсэж болзошгүй байна.

Б. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, УЛСЫН ТӨСВӨӨС ОЛГОСОН САНХҮҮЖИЛТИЙН ЗАРЦУУЛАЛТ ҮР ДҮНТЭЙ БАЙНА.

Б.1 Гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулсан байна.

Б.1.1 Төсөл арга хэмжээг тайлант онд хэрэгжих боломжтой хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Булган аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаас эрх шилжиж ирсэн /Халуун усны барилга Булган, Могод сум/ 1, өмнөх онд эрх шилжиж ирсэн Соёлын төвийн тоног төхөөрөмж бэлтгэх төсөл арга хэмжээ нь 250.0 сая төгрөгийн төсөвт өрөгтэй 2021 онд 75, 2022 онд 175 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор батлагдсан захиалагч байгууллага тухай оны санхүүжилтэд тааруулж техникийн тодорхойлол бэлтгэн худалдан авах ажиллагааг зарлуулсан, тайлант онд үлдэгдэл санхүүжилт 175.0 сая төгрөгийн санхүүжилтэд Соёл урлагийн газраас техникийн тодорхойлолтыг “Хөгжим, яригч, тоног төхөөрөмж” 106.9, “Камер, Видео проектор, тоног төхөөрөмж” 68.1 сая төгрөгөөр гэсэн 2 багц болгон хүргүүлсэн байна. Мөн БОАЖС-ын багцаас эрх шилжиж ирсэн 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээ нийт 5 худалдан авах ажиллагааг Орон нутгийн өмчийн газар зохион байгуулжээ.

Хүснэгт № 2 Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан төсөл арга хэмжээ /сая.төг/

№	Хуулийн дугаар	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	тайлбар
---	----------------	--------------------------	--------------	---------

1	XII.1.150	Халуун усны барилга /Булган, Могод сум/	165	2022.01.13 зарлаж 2022.02.14-ны өдөр нээхэд "Би Юу Эм Ди" ХХК 160, "Барилга эрч" ХХК 164.9 сая төгрөгөөр гүйцэтгэхээр санал ирүүлсэн боловч шаардлага хангаагүй хасагдсан, 2022.03.17-нд 2 дахь удаа зарлахад 1 оролцогч материал ирүүлж 163.5 сая төгрөгөөр гүйцэтгэхээр шалгарсан
2	БОАЖЯ/ 202202048	Аялал жуулчлалын байгаль, түүх соёлын өв бүхий газруудад ариун цэвэр, авто зогсоол бүхий отоглох цэг /Улсын хэмжээнд Хануй голын рашаан /Булган аймаг, Баян-Агт сум	100	Худалдан авах ажиллагааг цахимаар 6 удаа зарласан эхний 5-д санал ирүүлсэн оролцогч байхгүй, 6 дахь удаа зарлахад 3 оролцогч материал ирүүлж "Цонхот" ХХК 99.9 шалгарсан "Ди энд и минерал" ХХК 99.0 баримт дутуу ирүүлсэн, "Тана-Орд" ХХК 99.6 татварын өртэй тул хасагдсан байна
3	БОАЖЯ/ 202202049	Аялал жуулчлалын байгаль, түүх соёлын өв бүхий газруудад ариун цэвэр, авто зогсоол бүхий отоглох цэг /Улсын хэмжээнд Элсэн тасархай /Булган аймаг, Рашаант сум/	100	Худалдан авах ажиллагааг цахимаар 6 удаа зарласан эхний 5-д санал ирүүлсэн оролцогч байхгүй, 6 дахь удаа зарлахад 2 оролцогч материал ирүүлж "Ди энд и минерал" ХХК 99.2 сая төгрөгөөр гүйцэтгэхээр санал ирүүлж их бүрдэл дутуу тул хасагдсан, "Өвөлжөөн булаг" ХХК 99.1 сая төгрөгөөр гүйцэтгэхээр санал ирүүлж шалгарсан байна.
4	XIV.3.1	Соёлын төвийн тоног төхөөрөмж /Булган/ Багц-1 Хөгжим, яригч, тоног төхөөрөмж	106.9	"Цуурай" ХХК 106.7 сая төгрөгөөр гүйцэтгэхээр материал ирүүлж шалгарсан
5	XIV.3.1	Соёлын төвийн тоног төхөөрөмж /Булган/ Багц-2 Камер, Видео проектор, тоног төхөөрөмж	68.1	5 оролцогч материал ирүүлсэн "Хай теч солун" ХХК 66.0 шалгарсан, "НОЗА" ХХК 65.3 шаардлага хангаагүй, "Голденхоул" ХХК үнийн санал өндөр, "Би Си Ти" ХХК 38.4, "Сувдан элс" 68.1 шаардлага хангаагүй хасагдсан байна.
		ДҮН	540.0	

Эрх шилжиж ирсэн 540.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээнээс 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 6 удаа зохион байгуулснаас 5 удаад нь оролцогч санал ирүүлээгүй шалтгаанаар хугацаа алдсан ч төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн, бусад төсөл, арга хэмжээний хувь худалдан авах ажиллагааг тайлант онд хэрэгжих боломжтой байдлаар зохион байгуулсан байна.

Шинээр 165.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл арга хэмжээний үнэлгээний хороог төлөвлөсөн хугацаанаас 7 хоногийн хэтрүүлсэн байна.

Б.1.2 Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулж, батлуулсан байна.

Эрх нь шилжиж ирсэн 540.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээний 5 худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороод нь тендерийн баримт бичгийг ТБОНӨХБАҮХАТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2 -д заасны дагуу тендерийн баримт бичигт тендерт оролцогч зохих шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай мэдээлэл, тендерт оролцогчдод тавих шаардлага, сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, зураг, тендерийн жишиг маягтуудыг бэлтгэн Сангийн сайдын 2021

оны 194 дүгээр тушаалаар баталсан тендерийн жишиг баримт бичгийн дагуу боловсруулан батлуулсан байна.

Б.1.3 Гүйцэтгэгчийг ил, тод нээлттэй байдлаар сонгон шалгаруулсан байна.

Аймгийн Засаг даргад 2022 онд эрх шилжүүлсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих барилга байгууламж 1, их тоног төхөөрөмжийн 1 төсөл арга хэмжээний 2 багц, БОАЖС-аас 2 нийт 5 ажлын тендерийн гүйцэтгэгчийг аймгийн Орон нутгийн өмчийн газраас сонгон шалгаруулсан байна. Тус аймгийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон тендер шалгаруулалттай холбоотой мэдээлэл, тендерт шаардлагатай бүрдүүлэх материал, урилгыг хэвлэл, цахим сайтаар олон нийтэд нээлттэй мэдээлж, тендер шалгаруулалтыг зарлахдаа тендерийн урилга болон холбогдох баримтуудыг “tender.gov.mn”, өдөр тутмын сонинд мэдээлж, сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж ажилласан байна.

Б.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 1 ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ ГЭРЭЭНД ЗААСАН ХУГАЦААНД ГҮЙЦЭТГЭЭГҮЙ БУСАД ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ БҮРЭН ХЭРЭГЖСЭН БАЙНА.

Б.2.1 Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөснөөс 70 хувийн гүйцэтгэлтэй 1 ажил гэрээний хугацаандаа хэрэгжээгүй зогссон байна.

Булган аймагт эрх шилжсэн он, дамжин хэрэгжиж буй 3589.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3, шинээр хэрэгжиж буй 1, БОАЖС-ын багцаас 2 нийт 365.0 сая төгрөгийн 6 барилга, байгууламжийн төсөл арга хэмжээ батлагдсанаас 2020 онд ашиглалтад орсон 1 төсөл арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт 197.3, хэрэгжиж байгаа 5 төсөл арга хэмжээний 3 нь гэрээнд тусгагдсан ажил бүрэн хэрэгжиж, 1 төсөл арга хэмжээ ажил дуусаж улсын комисс ажилласан ч үүрэг даалгавар өгч гэрээг 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдөр хүртэл сунгасан, 1 төсөл арга хэмжээний гүйцэтгэл 70 хувьтай байна.

Хүснэгт № 3 Он дамжин хэрэгжиж буй төсөл арга хэмжээний гүйцэтгэл /сая.төг/

№	Төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	2022 санхүүжих	Гэрээний дуусах хугацаа	Ажлын гүйцэтгэл /тайлбар/
		Эхлэх	Дуусах				
1	Сургуулийн өргөтгөлийн барилга, 240 суудал /Булган, Хутаг-Өндөр сум/	2019	2022	1500	197.3		2020 онд ашиглалтад орсон үлдэгдэл санхүүжилт
2	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 75 ор /Булган, Булган сум, 3 дугаар цэцэрлэг/	2020	2021	1169.6	245.7	2023.03.30	Ашиглалтад оруулах улсын комисс ажилласан, үүрэг даалгавар өгч гэрээг сунгасан
3	Хүүхдийн "Жаргалант" зуслангийн захиргаа, аж ахуй, гал тогооны барилга	2020	2022	920	255		Гэрээний ажил дуусаж хүлээн авсан

/Булган/						
Дүн			3589.6	698.0		

Хүүхдийн "Жаргалант" зуслангийн захиргаа, аж ахуй, гал тогооны барилга /Булган/ төсөл арга хэмжээ нь 2013 оны 925.0 сая төгрөгийн зураг төсөвтэй 2020 онд зураг төсөвт магадлал хийж 1198.0 төгрөгийн төсөвт өртөгтэй болсон, улсын төсөвт хуучин зураг төсвийн өртөг буюу 925.0 сая төгрөгөөр батлагдаж, төсөвт багтаан үндсэн барилгын ажлыг гүйцэтгүүлэхээр худалдан авах ажиллагааг зарлаж "Эрдэнэс эко үүр" ХХК 920.0 сая төгрөгөөр гэрээнд тусгагдсан ажлыг хийж гүйцэтгэн, ашиглалтад оруулах комисс 2022 оны 12 дугаар сарын 19-ний дүгнэлт гарган хүлээж авсан байна.

Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 75 ор /Булган, Булган сум, 3 дугаар цэцэрлэг/ төсөл арга хэмжээг "Виртуалсофт" ХХК 905.0 сая төгрөгөөр 2020 оны 06 дугаар сарын 30-наас 2021 оны 11 дүгээр сарын 02-ны дотор хийж гүйцэтгэхээр гэрээг байгуулсан ч ковид цар тахалтай холбоотой бараа материалын хомсдол үүссэн тул гэрээг сунгах хүсэлт гаргаж 2022 онд дуусгахаар гэрээ байгуулсан байна. Барилгын ажлыг хүлээн авах улсын комисс ГХБХБГ-дарын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/107 тушаалаар 15 хүний бүрэлдэхүүнтэй томилж, комисс ажиллаж 49/2022 тоот дүгнэлт гаргаж үүрэг даалгавар өгч гэрээг 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдөр хүртэл сунгасан байна.

Шинээр эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн талаар:

2022 онд аймгийн Засаг даргад 165.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй халуун усны барилгын 1, БОАЖС-ын багцаас 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 суманд хийгдэх аялал жуулчлалын отоглох цэгийн 2 төсөл арга хэмжээ эрх шилжин ирж хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт № 4 "Тайлант онд эрх шилжсэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл" /сая.төг/

№	Төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	2022 санхүүжих	Гэрээний дуусах хугацаа	Ажлын гүйцэтгэл /тайлбар/
1	Халуун усны барилга /Булган, Могод сум/	2022	2022	165.0	103.1	2022.07.22	70 хувь
2	Аялал жуулчлалын байгаль, түүх соёлын өв бүхий газруудад ариун цэвэр, авто зогсоол бүхий отоглох цэг /Улсын хэмжээнд Хануй голын рашаан /Булган аймаг, Баян-Агт сум	2022	2022	100.0	100.0	2022.08.05	2022.08.02 41/2022
3	Аялал жуулчлалын байгаль, түүх соёлын өв бүхий газруудад ариун цэвэр, авто зогсоол бүхий отоглох цэг /Улсын хэмжээнд Элсэн тасархай /Булган аймаг, Рашаант сум/	2022	2022	100.0	100.0	2022.10.25	2022.11.14 комиссын 30/2022 дугаар акт
	Дүн			365.0	365.0		

Дээрх төсөл арга хэмжээнээс 165.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл арга хэмжээ нь дуусаагүй он дамжиж, 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээ нь бүрэн дуусаж хүлээлгэн өгсөн байна. Үүнээс гэрээний хугацаанд дуусаагүй төсөл арга хэмжээг авч үзвэл:

Халуун усны барилга /Булган, Могод сум/ төсөл арга хэмжээ нь 2020 онд хийсэн зураг төсөвтэй, 2022 оны улсын төсөвт 165.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр баталсан, худалдан авах ажиллагааг зохион байгуулж 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс 2022 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн дотор хийж гүйцэтгэхээр гэрээг байгуулжээ. Барилгын ажил 70 хувийн гүйцэтгэлтэй 103.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон ч үлдэгдэл ажлыг хийж гүйцэтгэх хугацаанд зураг төсвийг магадлалаар хянуулаагүй учраас санхүүжилтийг олгоогүй ажил зогссон байна.

Б.2.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжиж ирсэн их засварын ажил байхгүй байна.

Б.2.3 Техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу 17 нэр төрлийн 89 ширхэг тоног төхөөрөмжийг бүрэн нийлүүлсэн байна.

Соёлын төвийн тоног төхөөрөмж бэлтгэх төсөл арга хэмжээ нь 2021 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтад 250.0 сая төгрөгийн өртөгтэй 2021 онд 75.0 сая төгрөгийн санхүүжиж он дамжин хэрэгжих төсөл арга хэмжээгээр баталсан, захиалагч байгууллага батлагдсан төсвийн хүрээнд буюу 75.0 сая төгрөгт техникийн тодорхойлолтыг бэлтгэн худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар шийдвэрлэсэн байна.

2022 онд үлдэгдэл санхүүжилт болох 175.0 сая төгрөг батлагдаж, худалдан авах ажиллагааг “Хөгжим, яригч, тоног төхөөрөмж” 106.9, “Камер, Видео проектор, тоног төхөөрөмж” 68.1 сая төгрөгөөр 2 багц болгон техникийн тодорхойлолтыг Соёл урлагийн газраас боловсруулсны дагуу зохион байгуулж, гүйцэтгэгч компани гэрээний дагуу нийлүүлжээ.

Хүснэгт № 5 Тайлант онд эрх шилжсэн техник, тоног төхөөрөмжийн гүйцэтгэл /сая.төг/

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний нэр-задалсан нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	Гэрээний дүн	Гэрээний дуусах хугацаа	Ажлын гүйцэтгэл /тайлбар/
			Эхлэх	Дуусах				
1	Соёлын төвийн тоног төхөөрөмж	Хөгжим, яригч, тоног төхөөрөмж	2022	2022	106.9	106.7	2022.06.20	2022.07.05 хүлээн авсан.
2	Камер, Видео проектор, тоног төхөөрөмж /Булган/	Камер, Видео проектор, тоног төхөөрөмж	2022	2022	68.1	66	2022.06.24	2022.06.23 хүлээн авсан.
	Дүн				175.0	172.7		

Ажлыг хүлээн авах комиссыг Соёл урлагийн газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/04 тушаалаар 6 хүний бүрэлдэхүүнтэй томилон, ажиллаж техникийн тодорхойлолтод заасан даалгаврын дагуу харьцуулан хүлээн авчээ.

Соёлын төвийн тоног төхөөрөмж /Булган/ багц-1 төсөл арга хэмжээний 106.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэхээр шалгарсан “Цуурай” ХХК нь 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдөр гэрээ сунгах хүсэлт хүргүүлсэн ч гүйцэтгэгч, захиалагч гэрээг сунгаагүй гэрээнд заасан хугацаанаас 13 хоногоор хоцроож 0.7 сая төгрөгийн алдангийг тооцож суутгаагүй байна.

Б.2.4 Төсөл арга хэмжээний ТЭЗҮ ангилалд тусгагдсан төсөл, арга хэмжээ байхгүй байна.

Б.2.5 Он дамжсан дуусаагүй орхигдсон төсөл, арга хэмжээ байхгүй байна.

Булган аймагт он дамжсан болон шинээр хэрэгжсэн хэрэгжсэн 2634.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ажил хэрэгжиж байгаагаас 4 төсөл арга хэмжээ нь бүрэн хэрэгжиж, 1 төсөл арга хэмжээнд улсын комисс ажилласан үүрэг даалгавар өгч хугацааг сунгасан, 1 төсөл арга хэмжээний ажил 70 хувьтай байна.

Хэрэгжиж дуусаагүй орхигдсон барилга, байгууламж нийлүүлээгүй тоног төхөөрөмж байхгүй байна.

Б.3 ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ТАЙЛАН МЭДЭЭГ ҮНДЭСЛЭН САНХҮҮЖИЛТИЙГ ОЛГОЖЭЭ.

Б.3.1 Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн хугацаанд нь бүрэн олгосон байна.

Аймгийн ЗДТГ нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-д зааснаар төсөл, арга хэмжээ бүрээр захиалагчийн хянаж, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлийг үндэслэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг олгох ёстой.

2022 онд орон нутагт хэрэгжиж буй 6, өмнөх онд ашиглалтад орсон 1 нийт 7 төсөл арга хэмжээнд 1238.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдаж, 1177.4 сая төгрөгийг олгожээ.

Хүснэгт №6 2022 оны олгосон санхүүжилт, зарцуулалтыг хүснэгтээр харуулбал /сая.төг/

№	Төсөл арга хэмжээ	Шинэ, шилжих	2022 онд баталсан санхүүжилт	Нийт олгосон	Үүнээс		
					Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан	Зураг төсөв, техник хяналтад	Гүйцэтгэгч олгосон
1	Хүүхдийн “Жаргалант” зуслангийн захиргаа, аж ахуй, гал тогооны барилга /Булган/	Шилжих	255	255	3.9	1.2	249.9
2	Сургуулийн өргөтгөлийн барилга, 240 суудал /Булган, Хутаг-Өндөр сум/	Шилжих	197.3	197.3		5.1	192.2
3	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 75 ор /Булган, Булган сум, 3 дугаар цэцэрлэг/	Шилжих	245.7	244.8	6.4		238.4
4	Халуун усны барилга /Булган, Могод сум/	Шинэ	165.0	112.3	9.2		103.1

5	түүх соёлын өв бүхий газруудад ариун цэвэр, авто зогсоол бүхий отоглох цэг /Улсын хэмжээнд Хануй голын рашаан /Булган аймаг, Баян-Агт сум	Шинэ	100.0	98.2	2.3		95.9
6	түүх соёлын өв бүхий газруудад ариун цэвэр, авто зогсоол бүхий отоглох цэг /Улсын хэмжээнд Элсэн тасархай /Булган аймаг, Рашаант сум/	Шинэ	100.0	97.1	1.7	0.9	94.5
7	Соёлын төвийн тоног төхөөрөмж /Булган/	Шинэ	175.0	172.7			172.7
	Дүн		1238.0	1177.4	23.5	7.2	1146.7

Дээрх журмын дагуу өмнөх оны эрх шилжсэн 3 төсөл арга хэмжээний 698.0 сая төгрөгийг олгохоор төсөвлөж, 697.1 төгрөгийн олгож үүнээс 10.3 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлж, 6.3 сая төгрөгийг захиалагч, зохиогчийн хяналт олгосон байна.

Тайлант онд шинээр эрх шилжсэн 540.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл арга хэмжээнээс 3 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж 368.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, хэрэгжилт дутуу 1 ажилд 112.3 сая төгрөгийн санхүүжилт ирснээс 103.1 сая төгрөгийн гүйцэтгэгчид олгож, үлдэгдэл 9.2 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан, уг төсөл арга хэмжээ нь зураг төсөв магадлалд хянуулаагүй шалтгаанаар ажил зогсож, санхүүжилт олгогдоогүй байна.

Гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулан гэрээний хавсралтаар санхүүжилтийн хуваарь, анхан шатны баримт болон төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлийн тайлан мэдээ, баримтыг үндэслэн санхүүжилтийг олгожээ.

Б.3.2 Нэмэлт санхүүжилтийн гэрээ хийсэн төсөл арга хэмжээ байхгүй.

Б.4 Төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих дотоод хяналтын тогтолцоо үр дүнгүй байна.

Б.4.1 Барилга угсралтын ажил гүйцэтгэсэн тэмдэглэл хийх дэвтэрт захиалагч, зохиогчийн хяналтын тэмдэглэл хөтлөөгүй байна.

Дэд бүтцийн хөгжлийн сайдын 2000 оны 1 дүгээр сарын 07-ны өдрийн 09 дүгээр тушаалаар баталсан “Барилга угсралтын ажил гүйцэтгэсэн тэмдэглэл хөтлөх журам”-ын 5-д “Хяналтын болон захиалагч бусад холбогдох байгууллагуудаас барилгын ажилтай танилцаж үзсэн тохиолдолд ямар шаардлага, зөвлөмж өгсөн биелэлтийг шалгасан тухай тэмдэглэлд тодорхой тэмдэглэнэ.” гэж заасны дагуу тэмдэглэл хөтөлсөн байх шаардлагатай.

Он дамжсан болон шинээр хэрэгжиж байгаа эрх шилжин хэрэгжсэн ирсэн 3-р цэцэрлэгийн барилгын өргөтгөл, хүүхдийн “Жаргалант” зуслангийн захиргаа, аж ахуй, гал тогооны барилга, Могод сумын халуун усны барилгын “Барилга угсралтын ажил гүйцэтгэсэн тэмдэглэл”-ийн дэвтэр хяналт хийсэн тухай баримт материалын хүрээнд аудит хийлээ.

“Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэл” буюу улаан журналыг барилгын ажилд нээсэн уг дэвтэрт 2022 онд гүйцэтгэгч ажлын тэмдэглэл хөтөлсөн,

захиалагч, зохиогчийн хяналтын тэмдэглэл хөтлөөгүй, аймгийн ОБГ-ийн байцаагч хяналт хийсэн 1 тэмдэглэлээс өөр хяналт хийсэн тухай бичилт байхгүй байна.

Захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн мэргэжилтнүүдээс тодруулахад: Барилгад хяналт хийсэн тухай илтгэх хуудас бичиж, зургаар баталгаажуулан ГХБХБГ-ын БХБХ-ийн даргаар хянуулдаг байна. Аудитын явцад хяналт хийсэн тухай илтгэх хуудсыг ирүүлсэн. Тухайлбал:

- Баримтад барилгын ажил эхлэхэд цэг тавьсан, ажлын зургаас өөр материал буюу хайрган гулдай буулгасан байсныг ашиглахгүй байх шаардлага тавьсан,
- Далд ажлын фото зураг байхгүй, байгааг захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагад танилцуулах,
- барилгын баруун талын душны өрөөний цонх гаргаагүй байгааг зохиогчтой зөвшилцөх,
- барилгын талбайд бохир усны кольцо хийхээр төлөвлөсөн байгааг ажлын зургийн дагуу хийх,
- Хяналт хийхээр очсон гүйцэтгэгч байхгүй байсан бохирын цооног 10м3 байхаар төлөвлөсөн ч гүйцэтгэгч 5.66 м3 хийхээр төлөвлөсөн тухай илтгэх хуудас бичиж газрын даргаар хянуулж, баталгаажуулсан байна.

Цаашид орон нутагт хэрэгжиж буй бүх төрлийн барилга байгууламж, өргөтгөл, шинэчлэлтийн ажил бүрд ажил эхэлсэн өдрөөс эхлэн ашиглалтад хүлээлгэн өгөх хүртэл тэмдэглэлийг бүрэн гүйцэт хөтөлж, холбогдох бичиг баримтын хамт архив хүлээлгэн өгч байх шаардлагатай байна.

Тоног төхөөрөмжийн 1 төсөл, арга хэмжээний 2 багц ажлыг Соёл урлагийн газрын даргын тушаалаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн хяналт тавьж, холбогдох газруудад комиссын актаар хүлээлгэн өгсөн байна.

Б.4.2 Хөрөнгө оруулалтын үйл явцад дотоод хяналтын тавих чиг үүрэг хэрэгжихгүй байна.

Төсвийн тухай хуульд Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулахаар заасан байна.

СХАА-ны аймгийн Засаг даргаар батлуулсан 2022 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд аливаа хөрөнгө оруулалтын ажлын үр дүнд хийх хяналт шалгалт тусгагдаагүй, УТХО-аар хийгдсэн ажлын үр дүнд ашиглагч, захиалагч байгууллагаас эрх бүхий албан тушаалтнууд хяналт шалгалт хийсэн тухай тэмдэглэл, баримт материал байхгүй байна.

Б.5 ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ХҮЛЭЭН АВАХ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА.

Б.5.1 Он дамжсан болон шинээр эрх шилжиж ирсэн 4 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж холбогдох хууль, журмын дагуу ажлыг хүлээн авч дүгнэлт гаргасан байна.

Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ын 5-д барилга байгууламжийг ашиглалтад оруулах чиг үүрэг, 7-д комиссын ажиллах журмыг мөрдөж хүлээн авах ажлыг зохион байгуулахаар заасан байна.

Орон нутагт эрх шилжиж ирсэн он дамжсан болон шинээр хэрэгжиж буй 6 төсөл арга хэмжээнээс бүрэн хэрэгжсэн 4, улсын комисс ажиллаж үүрэг даалгавар өгч гэрээг сунгасан 1, хэрэгжилт дутуу 1 төсөл арга хэмжээ байна.

Хүснэгт №7 2022 онд гэрээний хэрэгжилт биелсэн, хүлээн авсан төсөл арга хэмжээг хүснэгтээр харуулбал /сая.төг/

№	Төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Ажлын гүйцэтгэл /тайлбар/
		Дуусах	Хүлээн авсан	
1	Хүүхдийн "Жаргалант" зуслангийн захиргаа, аж ахуй, гал тогооны барилга /Булган/	2022.12.26	2022.12.19	Ашиглалтад оруулах комиссын 41/2022 акт
2	Аялал жуулчлалын байгаль, түүх соёлын өв бүхий газруудад ариун цэвэр, авто зогсоол бүхий отоглох цэг /Улсын хэмжээнд Хануй голын рашаан /Булган аймаг, Баян-Агт сум	2022.08.05	2022.08.02	Ашиглалтад оруулах комиссын 14/2022 акт
3	Аялал жуулчлалын байгаль, түүх соёлын өв бүхий газруудад ариун цэвэр, авто зогсоол бүхий отоглох цэг /Улсын хэмжээнд Элсэн тасархай /Булган аймаг, Рашаант сум/	2022.10.25	2022.11.17	Ашиглалтад оруулах комиссын 30/2022 акт
4	Соёлын төвийн тоног төхөөрөмж /Булган/ Багц 1- Хөгжим, яригч, тоног төхөөрөмж/	2022.06.20	2022.07.05	2022.07.05 хүлээн авсан.
5	Соёлын төвийн тоног төхөөрөмж /Булган/ Багц 2- /Камер, Видео проектор, тоног төхөөрөмж/	2022.06.24	2022.06.23	2022.06.23 хүлээн авсан.

Захиалагч байгууллагаас хүлээн авах комисс томилон ажлыг хүлээн авч ашиглалтад оруулах комиссын дүгнэлт, хурлын тэмдэглэл, үүрэг даалгаврын биелэлт холбогдох баримт материалыг журмын дагуу бүрдүүлж ажилласан байна.

Б.5.2 Ашиглалтад хүлээн авсан төсөл арга хэмжээнээс гэрээнд заасан хугацаанаас хоцорсон 1 ажлын 0.7 сая төгрөгийн алданги тооцоогүй байна.

Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор “барилгын ажлын захиалагчийн дүрэм” 3.6-д “Захиалагч зураг төсөл зохиогч болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг тогтоосон хугацаанд дүгнэж, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, эсхүл зөрчил, дутагдал илэрсэн тохиолдолд гэрээ болон хууль тогтоомжид заасан хариуцлагыг тооцож ажиллана.” гэж заасан.

Гэрээний хэрэгжилт хангагдаж, бүрэн хэрэгжсэн ажлын төсөл арга хэмжээг хүлээн авахдаа улсын комисс дүгнэлт болон хурлын тэмдэглэлээр баталгаажуулан гэрээ хэрэгжилтийг дүгнэх маягт хөтлөн биелэлтийг тооцдог ч

захиалагч, гүйцэтгэгч гэрээний дагуу үүргээ биелүүлэлтийн талаар дурдаагүй байна.

Гэтэл 4 төсөл арга хэмжээнээс 1 ажил гэрээний үүргээс 13 хонгийн хугацаа хоцорч хүлээлгэн өгсөн байна. Үүнд:

❖ Соёлын төвийн тоног төхөөрөмж /Булган/ багц-1 “Хөгжим, яригч, тоног төхөөрөмж”-ийн ажил нь 2022 оны 06 сарын 20-ны өдөр дуусгахаар гэрээг байгуулж, ажлыг 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр хүлээлгэн өгч 13 хоног хугацаа хэтэрч гэрээнд заасан хувь хэмжээгээр алданги тооцон үзэхэд 0.7 сая төгрөгийг суутган тооцоогүй зэрэг зөрчлийг гэрээний үүргийн биелэлтэд тооцоогүй, тэмдэглэлд дурдаагүй байна.

Б.5.3 Хөрөнгө оруулалтаар бий болсон 1,115.3 сая төгрөгийн 3 барилга байгууламжийн өмчлөлийн асуудлыг шийдвэрлээгүй байна.

2022 онд он дамжин хэрэгжих байгаа 920.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1, шинээр хэрэгжсэн 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 барилга байгууламж бүрэн ашиглалтад орж, тоног төхөөрөмж нийлүүлэх 175.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл арга хэмжээний 2 багцын нийт 1295.0 сая төгрөгийн ажил бүрэн хэрэгжиж захиалагч байгууллагад хүлээлгэн өгсөн байна.

Үүнээс ашиглагч байгууллагад хүлээлгэн өгч, данс бүртгэлд соёлын төвийн тоног төхөөрөмжийн 172.7 сая төгрөгийн хөрөнгөөс бусад ажлаас бий болсон хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

Хүснэгт №8 Бүртгэлд авсан байгууллагын жагсаалтыг хүснэгтээр харуулбал /сая.төг/

№	Сум, байгууллагын нэр	Дүн	Тайлбар
1	Соёл урлагийн газар	22.74	4 нэр төрлийн 5 ширхэг тоног төхөөрөмж
2	Хөгжимт жүжгийн театр	8.69	Дижитал пульт 1 ширхэг
3	Төв Номын сан	6.19	Зөөврийн компьютер 2, принтер 1 ширхэг
4	Музей	15.71	Камер 1 ширхэг
5	Булган сумын Соёлын ордон	6.36	3 нэр төрлийн 6 ширхэг тоног төхөөрөмж
6	Орхон сумын Соёлын төв	9.48	3 нэр төрлийн 22 ширхэг тоног төхөөрөмж
7	Могод сумын Соёлын төв	10.93	7 нэр төрлийн 9 ширхэг тоног төхөөрөмж
8	Дашинчилэн сумын соёлын төв	5.09	Зөөврийн компьютер 2 ширхэг
9	Гурванбулаг сумын Соёлын төв	9.70	4 нэр төрлийн 4 ширхэг тоног төхөөрөмж
10	Бүрэгхангай сумын Соёлын төв	10.93	7 нэр төрлийн 9 ширхэг тоног төхөөрөмж
11	Бугат сумын Соёлын төв	8.09	3 нэр төрлийн 5 ширхэг тоног төхөөрөмж
12	Баян-Агт сумын Соёлын төв	13.48	9 нэр төрлийн 16 ширхэг тоног төхөөрөмж
13	Хутаг-Өндөр сумын Соёлын төв	2.80	Принтер, Чадлын өсгөгч 2ш тоног төхөөрөмж
14	Рашаант сумын Соёлын төв	15.14	5 нэр төрлийн 8 ширхэг тоног төхөөрөмж
15	Сэлэнгэ сумын Соёлын төв	10.93	7 нэр төрлийн 9 ширхэг тоног төхөөрөмж
16	Хангал сумын Соёлын төв	1.97	Чадлын өсгөгч 1 ширхэг
17	Хишиг-Өндөр сумын Соёлын төв	3.52	1 ш караоке машин
18	Хялганат тосгоны Соёлын төв	10.93	7 нэр төрлийн 9 ширхэг тоног төхөөрөмж
	Дүн	172.70	

Аймгийн Соёл урлагийн газраас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн 172.7 сая төгрөгийн хөрөнгийг соёлын салбарын 18 байгууллагад 17 нэр төрлийн 89 тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгч данс бүртгэлд тусгасан байна.

Ашиглагч байгууллагад шилжүүлээгүй хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй дараах төсөл арга хэмжээнүүд байна.

Хүснэгт №9 Бүртгэлд тусгаагүй төсөл арга хэмжээний жагсаалт

/сая.төг/

№	Төсөл арга хэмжээний нэр	Ажлын гүйцэтгэл /тайлбар/	Бүртгэлд тусгаагүй хөрөнгийн дүн
1	Хүүхдийн "Жаргалант" зуслангийн захиргаа, аж ахуй, гал тогооны барилга /Булган/	Ашиглалтад оруулах комиссын 41/2022 акт	920.0
2	Аялал жуулчлалын байгаль, түүх соёлын өв бүхий газруудад ариун цэвэр, авто зогсоол бүхий отоглох цэг /Улсын хэмжээнд Хануй голын рашаан /Булган аймаг, Баян-Агт сум	Ашиглалтад оруулах комиссын 14/2022 акт	99.9
3	Аялал жуулчлалын байгаль, түүх соёлын өв бүхий газруудад ариун цэвэр, авто зогсоол бүхий отоглох цэг /Улсын хэмжээнд Элсэн тасархай /Булган аймаг, Рашаант сум/	Ашиглалтад оруулах комиссын 30/2022 акт	97.1
	Дүн		1,117.0

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 17 дугаар тогтоолоор баталсан “орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх данснаас хасах шилжүүлэх” журамд улс орон нутгийн төсвөөр бий болсон үндсэн хөрөнгийг тухай бүр нь Өмчийн албанд бичгээр мэдэгдэж, хянуулсны дараа байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгаж байхаар заасан ч хэрэгжүүлж ажиллаагүй хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн бүртгэл хангалтгүй байна.


В.1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ЖИЛИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ БҮРЭН НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.

В.1.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар батлагдсан төсөл арга хэмжээний 54.5 хувийг жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгаагүй байна.

Аймгийн ИТХ-аар 2021 оны 12 дугаар сарын 02-ний өдрийн V/04 тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад барилга байгууламж, тоног төхөөрөмж, их засварын 2,838.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 17 ажлын баталжээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад аймгийн ИТХ-аар 2022 оны 06 дугаар сарын 23 -ны өдрийн IX/16 тогтоолоор өөрчлөлт оруулан барилга байгууламж, тоног төхөөрөмж, их засварын 715.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16 төсөл, арга хэмжээг нэмж нийт 3,553.8 сая төгрөгийн 33 ажил болгон баталжээ. Үүнийг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл №1 Төлөвлөсөн төсөл, арга хэмжээ ангиллаар



Эдгээр 33 төсөл, арга хэмжээ нь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны шинэ хөгжлийн зам хөтөлбөрүүдэд бүрэн нийцсэн байна.

Харин аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 02 -ны өдрийн V/03 тогтоолоор баталсан Булган аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй 18 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

1. Барилга, байгууламжийн 2 төсөл, арга хэмжээ / Баян-Агт сумын ЗДТГ-ын цахилгаан хангамжийн нэмэлт ажил 40.0 сая, Бугат сумын төвийн гэрэлтүүлэг 80.0 сая /
2. Их засварын 8 төсөл, арга хэмжээ / хавсралт-1/
3. Тоног төхөөрөмжийн 8 төсөл, арга хэмжээ /Хавсралт-1/

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 33 төсөл, арга хэмжээг аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт бүрэн тусгасан сайн тал байгаач баталсан хөрөнгө оруулалтын 54.5 хувь буюу 18 төсөл, арга хэмжээг жилийн хөгжлийн төлөвлөгөөнд уялдуулан батлаагүй байна.

В.1.2 ОНХО-аар зураг төсөв, ТЭЗҮ хийгдээгүй 16 төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх 3,553.8 сая төгрөгийн 33 төсөл, арга хэмжээг баталснаас Төсвийн тухай хуулийн 29.4⁴ -д нийцүүлэн төлөвлөөгүй 1,001.8 сая төгрөгийн 16 төсөл, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлжээ.

Хүснэгт №10 Зураг төсөв, ТЭЗҮ хийгдээгүй төсөл, арга хэмжээ

/сая.төг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний ангилал	Төсөвт өртөг
1	2	3	4
1	Шүүхийн шинжилгээний албаны төрийн тусгай албан хаагчийн орон сууц худалдан авах	Барилга байгууламж	60.00
2	Сумын төвийн гэрэлтүүлэг (Бугат сум)	Барилга байгууламж	80.00
3	Ариутгалын ДУК автомашин	Тоног төхөөрөмж	50.00
4	Хог зам засварын техник (Баян-Агт сум)	Тоног төхөөрөмж	74.99

⁴ 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

5	Хөгжимт жүжгийн театрын тайзны техник хэрэгсэл, засвар үйлчилгээ (Булган сум)	Тоног төхөөрөмж	10.00
6	Хөгжимт жүжгийн театрын бүжигчид, дуучдын хувцас хэрэглэл (Булган сум)	Тоног төхөөрөмж	15.00
7	Спортын дунд сургуулийн хяналтын камер (Булган сум)	Тоног төхөөрөмж	9.50
8	Өрхийн эрүүл мэндийн төвийн автомашин (Булган сум эмийн цэцэглэн өрхийн эрүүл мэндийн төв)	Тоног төхөөрөмж	20.00
9	Хог зам засварын техник (Хангал сум, Хялганат тосгон)	Тоног төхөөрөмж	70.00
10	Орон нутгийн өмчийн барилга, байгууламж барих (Тэшиг сум)	Их засвар	50.00
11	Орон нутгийн өмчийн барилга, байгууламж барих (Хутаг-Өндөр сум)	Их засвар	50.00
12	Соёлын төвийн засвар /Сэлэнгэ сум/	Их засвар	350.00
13	Ахуйн үйлчилгээний барилгын засвар /Гурванбулаг сум/	Их засвар	100.00
14	Эрэн хайх аврах бүлгийн байрны засвар (Хутаг-Өндөр сум)	Их засвар	30.00
15	18-ийн а/б дугаар байрны фасадны зураг зурах ажил (Булган сум)	Их засвар	12.30
16	18-ийн а/б дугаар байрны фасадны зураг зурах бэлтгэл үе бэлтгэх засвар (Булган сум)	Их засвар	20.00
Нийт дүн			1,001.79

Дээрхээс үзэхэд барилга байгууламжийн 140.0 сая төгрөгийн 2, тоног төхөөрөмжийн 249.5 сая төгрөгийн 7, их засварын 612.3 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээг зураг, төсөв, ТЭЗҮ хийгдээгүй ажлыг төсөвт тусгасан нь хөрөнгө оруулалтын батлагдсан төсвийн 28.2 хувийг төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ байна.

В.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ 84.8 ХУВИЙН ГҮЙЦЭТГЭЛТЭЙ БАЙНА.

В.2.1 Худалдан авах ажиллагааны журмыг сонгох босго үнийг баримтлаагүй 1 төсөл арга хэмжээ байна.

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 33 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шууд гэрээ байгуулсан 8, нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 9, харьцуулалтын аргаар 16 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж сонгон шалгаруулсан байна.

Үүнээс худалдан авах ажиллагааг зарласнаас хойш дараах төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын журмыг өөрчлөн гэрээг байгуулсан төсөл, арга хэмжээг авч үзвэл:

Нээлттэй тендер шалгаруулалтаар зарласан Орхон сумын сургуулийн барилгын засвар 230.0, Сэлэнгэ сумын соёлын төвийн барилгын засварын 350.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2 удаа цахим зарлаж шаардлага хангасан оролцогч материал ирүүлээгүй тул хуулийн дагуу Засаг даргад зөвлөмж хүргүүлэн шууд гэрээ байгуулсан байна.

Тэшиг сумын уурын зуухны тогооны 90.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2022 оны 08 дугаар сарын 11, 30-ний өдрүүдэд харьцуулалтын аргаар 2 удаа зарласан ч оролцогч материал ирүүлээгүй байна. Тэшиг сумын онцгой комиссын 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн хурлаар уурын зуухны тогооны ажилд оролцогч ороогүй тул аймгийн Засаг даргад шууд гэрээ байгуулах хүсэлт хүргүүлж шийдвэрлэжээ.

Харин худалдан авах ажиллагааны журмыг сонгох босго үнийг баримтлаагүй дараах төсөл, арга хэмжээ байна.

Үүнд: Булган сумын 14 байрны дээврийн засварын 95.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг худалдан авах ажиллагаа зарлаагүй шууд гэрээ байгуулсан нь аймгийн МХГ, ОБГ-аас тус барилгын дээвэрт ус нэвчин, цахилгаан угсралтын схемд орж гал түймэр гарах нөхцөл бүрдсэн гэсэн дүгнэлт гарсантай холбоотой хөрөнгийн шийдвэрлэж шууд гэрээг байгуулсан байна.

Бусад төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд, хууль журамд заасан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

В.2.2 Бүрэн хэрэгжсэн 2,370.8 сая төгрөгийн 28 төсөл, арга хэмжээг захиалагч байгууллагаас хүлээн авах комисс томилон ажлыг ашиглалтад оруулах комиссын тухай бүрд нь томилон ажилладаг байна.

2022 онд аймгийн ОНХО-аар баталсан 3,553.8 сая төгрөгийн 33 төсөл, арга хэмжээнээс 2,370.8 сая төгрөгийн 28 төсөл, арга хэмжээ нь тайланд онд бүрэн хэрэгжиж хүлээн авсан, 5 төсөл, арга хэмжээ нь дараа онд шилжин хэрэгжиж байна.

Хүснэгт №11 Он дамжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ

/сая.төг/

№	Төсөл, арга хэмжээ	Эхлэх	Дуусах	Гэрээний дүн	2022 онд олгосон санхүүжилт	Зөрүү
1	Хяналтын камерын хүчин чадлыг нэмэгдүүлэх /Булган сум/	2022	2022	49.9	24.3	25.54
2	Орон нутгийн өмчийн барилга, байгууламж барих (Тэшиг сум)	2022	2022	49.9	38.6	11.30
3	Орон нутгийн өмчийн барилга, байгууламж барих (Хутаг-Өндөр сум)	2022	2022	115.0	-	115.00
4	Хог хаягдлыг тээвэрлэх зориулалтын тоноглогдсон автомашин (Булган сум, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, Могод, Бугат, Дашинчилэн сум)	2022	2022	430.5	-	430.53
5	Ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын заалны дээврийн засвар (Баяннуур сум)	2022	2022	75.9	-	75.91

Баталсан хугацаанд дуусаагүй төсөл, арга хэмжээг дурдвал дараах байдалтай байна. Үүнд;

- Баяннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын заалны дээврийн засварын сонгон шалгаруулалтыг тайлант удаа 5 удаа зарлаж “ЭПО” ХХК-тай 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр гэрээ байгуулсантай холбоотой,
- Булган сум, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, Могод, Бугат, Дашинчилэн сумдын Хог хаягдлыг тээвэрлэх зориулалтын тоноглогдсон автомашиныг 2022 онд ковид-19 -ийн улмаас хил гаалиар нэвтрүүлэхэд хүндрэл учирсан тул гэрээг сунгасан байна,
- Хутаг-Өндөр сумын Орон нутгийн өмчийн барилга, байгууламж барих ажлыг сум нь өөрийн эх үүсвэрээр 65.0 сая төгрөгийн нэмж 115.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй болгон гэрээг 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдөр байгуулан он дамжин хэрэгжүүлэхээр болсон байна.

Бүрэн хэрэгжсэн 2,370.8 сая төгрөгийн 28 төсөл, арга хэмжээг захиалагч байгууллагаас хүлээн авах комисс томилон ажлыг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт, хурлын тэмдэглэл, үүрэг даалгаврын биелэлт холбогдох баримт материалыг журмын дагуу бүрдүүлж ажилласан байна.

В.2.3 ОНХО-ын гэрээний хэрэгжилтээс 72.5, хэрэгжээгүй 3 төсөл, арга хэмжээний 186.1 сая төгрөгийн хэмнэлт үүсэж орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Аймгийн ЗДТГ нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2, 4.3, дэх заалтад нийцүүлэн олгосон байна.

Тайлант онд нийт барилга байгууламж, тоног төхөөрөмж, их засвар нийт 3,553,8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 33 төсөл, арга хэмжээнээс 2022 онд 3,103.8 сая төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдаж 30 төсөл, арга хэмжээнд 2,433.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. /хавсралт №-2/

2022 онд олгохоор баталсан санхүүжилтээс үлдэгдэл болох 670.1 сая төгрөгийн үлдэгдэл санхүүжилт нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалтын дагуу худалдан авах ажиллагааны хүрээнд бий болсон хэмнэлтээс 72.5, хэрэгжээгүй 3 төсөл, арга хэмжээний 186.1 сая төгрөгийг орон нутгийн орлогын дансанд, 440.9 сая төгрөг дутуу болон он дамнан хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлжээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-ний гүйцэтгэгчид шилжүүлэх санхүүжилтээс гадна тухайн ажлын гэрээний үнийн дүнд багтсан захиалагчийн албаны зардалд 3.7 сая төгрөгийг ГХБХБГ-т, зураг төсөл зохиогчийн болон хяналтын зардлыг зураг төсөл, боловсруулсан аж ахуйн нэгжид 7.2 сая төгрөгийг тус тус шилжүүлжээ.

Нэгдсэн эмнэлгийн дотрын тасгийн засварын ажлыг “Танан орд” ХХК-иар гүйцэтгүүлсэн боловч гэрээнд заасан хугацааг 30 хоногоор хэтрүүлэн ажил хүлээлцэж санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгохдоо алданги болох 5.8 сая төгрөгийг суутган аваагүй байна.

Аймгийн санхүү төрийн сангийн хэлтэс нь гүйцэтгэлийг гарган холбогдох үе шатны хяналтаар орсны дараа санхүүжилтийг Захиалагч ТАХ-ний санхүүжилтийг олгохдоо тухайн ажлын гүйцэтгэлийн баримт, захиалагчийн болон зураг төсөл зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн баримт материал, ажлыг хүлээн авсан комиссын дүгнэлт зэргийг үндэслэж олгосон байна.

Аудитын явцад тайлант онд хэрэгжсэн ТАХ-ний ажлын гүйцэтгэл, түүний зураг төсөл зохиогч, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн баримт болон холбогдох бусад баримт материалаас үзэхэд ТАХ-ний санхүүжилтийг ажлын гүйцэтгэлд үндэслэн олгосон гэдгийг харуулж байна.

В.2.4 Захиалагчийн хяналтаар илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрд нь зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажилладаг байна.

Захиалагч болон зохиогчийн хяналт нь Барилгын тухай хуулийн 35, 37, 38.1.8, “Барилгын захиалагчийн хяналтын дүрэм”-ийн 2.2, 3.1.4, 3.4, 3.6, 3.12, 3.14 дэх заалтуудыг үндэслэн холбогдох яам, агентлаг, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үндсэн дээр хэрэгжиж байна.

Зохиогчийн хяналтын зардлыг зураг, төсөв зохиогч аж ахуйн нэгжид 7.2, захиалагчийн хяналтын зардалд 3.7 сая төгрөгийн ГХБХБГ-т олгосон байна.

Захиалагч нь зураг төсөл зохиогч нартай Барилгын тухай хуулийн 38 дугаар зүйлийн, 38.1.8 дахь заалтын дагуу зохиогчийн хяналтын гэрээ байгуулан үе шатны ажилбар бүрд хяналтыг хамтран хэрэгжүүлэн ажилладаг ч хяналтыг илтгэх хуудсаар гүйцэтгэн БХБХ-ын даргаар хянуулан ажиллажээ.

Аудитын явцад захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ГХБХБГ-аас хяналтын ажлын тайлан, холбогдох материалаас үзэхэд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд захиалагчийн хяналтын хэрэгжүүлэхэд илэрсэн зөрчил дутагдлаас дурдвал

- ✓ Могод сумын сургуулийн дотуур байрны барилгын засварын цонхны амлагаа дутуу, талбай суулт өгсөн,
- ✓ Гурванбулаг сумын ахуйн үйлчилгээний барилгын засварын цонхыг төсөв тусгасан 3 давхар шилтэйг 2 давхар шилээр сольсон, цонхны бэхэлгээ дутуу, аваарын шатны бэхэлгээ дутуу зэрэг зөрчлүүдийг арилгах талаар гүйцэтгэгчид үүрэг чиглэл өгч биелэлтийг тооцон ажилласан байна.

В.2.5 Тайлант онд хэрэгжсэн барилга, байгууламж, тоног төхөөрөмжөөс 1 төсөл, арга хэмжээг үнийн зөрүүтэй, 3 төсөл, арга хэмжээг бүртгэл тайланд тусгаагүй байна.

2022 онд хэрэгжсэн 80.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 барилга байгууламж бүрэн ашиглалтад орж, хүлээн авсан 493.6 сая төгрөгийн 12 тоног төхөөрөмж, 2 их засварын 267.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нийт 891.1 сая төгрөгийн ажил бүрэн хэрэгжиж бүртгэл тайланд тусгахаас 13 төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллагад хүлээлгэн өгч бүртгэлд тусгасан, 149.5 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг бүртгэн ажиллаагүй зөрчил илэрлээ.

Хүснэгт №12 Хөрөнгийн бүртгэлд тусгах төсөл, арга хэмжээний тоо, дүн /сая.төг/

№	Тоо ширхэг	Гэрээний дүн	Санхүүгийн тайланд орлогод аваагүй дүн		Санхүүгийн тайланд орлогод авсан дүн		Зөрүү	
			тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн
1	16	891.10	3	149.5	13	751.7	-	(10.1)

Хүснэгтээс үзэхэд санхүүгийн тайланд орлогод бүртгээгүй 149.5 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

1. Ариутгалын ДУК автомашин 50.0 сая төгрөг,
2. Булган сумын Спортын дунд сургуулийн хяналтын камер 9.5 сая төгрөг,
3. Тэшиг сумын Уурын зуухны халаалтын тогоо шинээр суурилуулах 90 төгрөг

Харин Бугат сумын төвийн гэрэлтүүлгийн ажлын 80.0 саяын төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд “Сервис по сименс” ХХК нь 69.9 сая төгрөгийн үнийн саналыг ирүүлж ажлыг гүйцэтгэж санхүүгийн тайланд баталсан төсөвт өртөг 80.0 сая төгрөгөөр орлогод авч бүртгэлд 10.1 сая төгрөгийн зөрүү бүртгэсэн байна.

ДҮГНЭЛТ: Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- ❖ Эрх шилжиж ирсэн 165.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг баталсан нь хөрөнгө оруулалтын ажил удаашрах, гэрээний хугацаанд хэрэгжиж боломжгүй болох, төсөвт өртөг нэмэгдэх эрсдэл үүссэн байна.
- ❖ БОАЖС-ын багцаас эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээ нь орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдсан, ажил болсон байна.
- ❖ Шинээр хэрэгжсэн төсөл арга хэмжээ нь тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих, бүртгэх боломжтой байна.
- ❖ ТЭЗ-ын баталсан 2022 оны хөрөнгө оруулалтын эрэмбэлсэн жагсаалтад Могод сумын халуун усны барилгын төсөл арга хэмжээ нь тусгагдаагүй, орон нутгийн саналгүй төсөл арга хэмжээ хэрэгжсэн байна.
- ❖ Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулж, ил тод нээлттэй байдлаар сонгон шалгаруулсан байна.
- ❖ Хөрөнгө оруулалтын ажлаас Могод сумын халуун усны барилгын 1 төсөл арга хэмжээг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй бусад төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.
- ❖ Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөснөөс 70 хувийн гүйцэтгэлтэй 1 ажил гэрээний хугацаандаа хэрэгжээгүй байна.
- ❖ Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн хугацаанд нь бүрэн олгосон байна.
- ❖ 2022 онд 7 төсөл арга хэмжээнд 1238.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдаж, ажлын гүйцэтгэлд үндэслэн 1177.4 сая төгрөгийг хугацаанд нь бүрэн олгосон байна.
- ❖ Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд дотоод хяналт хийсэн тухай баримт материал, тэмдэглэл байхгүй байна.

- ❖ Барилга угсралтын ажил гүйцэтгэсэн тэмдэглэл хийх дэвтэрт захиалагч, зохиогчийн хяналт хийсэн тухай тэмдэглэл, хөтлөлт хангалтгүй байна.
- ❖ Он дамжсан болон шинээр эрх шилжиж ирсэн 4 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж холбогдох хууль, журмын дагуу ажлыг хүлээн авч дүгнэлт гаргасан байна.
- ❖ Гэрээний хэрэгжилтийг тооцохдоо ашиглалтад хүлээн авсан төсөл арга хэмжээнээс гэрээнд заасан хугацаанаас хоцорсон 1 ажлын 0.7 сая төгрөгийн алданги тооцоогүй байна.
- ❖ Хөрөнгө оруулалтаар бий болсон 1115.3 сая төгрөгийн 3 барилга байгууламжийн өмчлөлийн асуудлыг шийдвэрлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ: Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна .

Аймгийн Засаг дарга Б.Ариун-Эрдэнэ, ХОХБТХ-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Давааням нарт:

- ❖ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал хүргүүлэхдээ орон нутгийн бодлого, шийдвэртэй уялдуулж байх.
- ❖ Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад газрын зөвшөөрөл болон бусад дүгнэлтүүд нь гарсан, техникийн нөхцөл нь бүрэн олгогдсон, зураг төслийн даалгаврыг боловсруулж, баталгаажуулсан, зураг төсөв нь урьдчилан хийгдсэн зэрэг төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээнүүдийг тусгуулах арга хэмжээ авах.
- ❖ Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлж биелэлт тооцдог байх.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга Ү.Бямбасүрэнд:

- ❖ Баригдаж байгаа бүх төрлийн барилга байгууламж, өргөтгөл, шинэчлэлтийн ажил бүрд “Барилга угсралтын ажил гүйцэтгэсэн тэмдэглэл”-ийн дэвтэр нээлгэж, хяналт хийсэн тухай тэмдэглэлийг хөтөлж хэвших.

Орон нутгийн өмчийн газрын дарга Т.Баттулгад:

- ❖ Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн өмчлөлийн асуудлыг тухай бүр нь шийдвэрлэж, ашиглагч байгууллагад шилжүүлж, бүртгэлд тусгаж байх.